



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020 09 09 № 20

Г Асуулга тавих тухай Т

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.” гэж заасан. Энэ нь Монголбанк үндсэн зорилтынхоо хүрээнд дотоодын санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлж ажиллах тухай зохицуулалт юм. Дэлхийн улс орнуудад Төв банк нь үнийн тогтвортой байдал буюу инфляциаа анхаарч, харин валютын ханшийн бодлогыг Төв банк нь Засгийн газартайгаа хамтран тодорхойлдог практик бий.

Манай улсын үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн ханш 2016 оны 06 дугаар сараас хойш 43.7 хувиар суларчээ. Монгол улсын нийт импортын 70 хувийг ам.доллар-аар хийдэг ба хэрэглээний сагсны 43.7 хувь нь импортын бараа байдаг. Тиймээс ам.долларын төгрөгтэй харьцах ханшийн чангаралтаас шалтгаалж импортын барааны болон өргөн хэрэглээний барааны үнэ өсч, энэ нь иргэдийн амьдралд шууд нөлөөлдөг. Монголбанкны 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн мэдээгээр ам.долларын төгрөгтэй харьцах хаалтын ханш 1,982.25 төгрөг байсан бол 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр 2,850.19 төгрөгт хүрч, даруй 867.94 төгрөгөөр өсөөд байна.

Энэ нь 2016 оноос хойш төгрөг 43.7 хувиар үнэгүйдсэн үзүүлэлт бөгөөд ам.долларын ханшны чангаралт гадаадын байгууллагуудтай хамтардаг Монголын бизнес эрхлэгчид, мөн ам.долларын зээлтэй зээлдэгчдийн хувьд асар хүнд дарамт болж байна. Хэдийгээр Монголбанк гадаад валютын нөөцөөсөө их хэмжээний ам.доллараар интервенц хийсээр ирсэн боловч төгрөгийн ханш улам бүр суларсаар байна. Ам.долларын ханш нэмэгдэх бүрт суурь үнээ хөөрөгдсөнөөр бага, дунд орлоготой иргэд, тэдний дотор тэтгэврийн орлоготой ахмадуудын амьдрал туйлын хүнд байдалд ороод байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-т тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Үндэсний статистикийн хорооноос гаргаж буй мэдээллээр M2 мөнгөний нийлүүлэлт 2012 оны 6 дугаар сард 7 их наяд 48 тэрбум төгрөг байсан бол 2016 оны 6 дугаар сард 11 их наяд 186 тэрбум төгрөгт, 2020 оны 7 дугаар сард 21 их наяд 356 тэрбум төгрөгт хүрч сүүлийн дөрвөн жилийн хугацаанд даруй 10 их наяд төгрөгөөр өсчээ. M2 мөнгөний хэмжээ ийнхүү асар ихээр нэмэгдсэн нь валютын ханшид хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийсэн бол танилцуулна уу?

2020000084

2. Монгол Улсын нийт өр 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр 24 тэрбум 260 сая ам.доллар байсан бол 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 30 тэрбум 461 сая ам.долларт хүрч дөрөвхөн жилийн хугацаанд 6 тэрбум 201 сая ам.доллар буюу бараг 18.0 их наяд төгрөгөөр өссөн байна. Харин Засгийн газрын нийт өр 2016 оны 2 дугаар улиралд 4,785.8 сая ам.доллар байсан бол 2020 оны эхний улиралд 7,235.4 сая ам.долларт хүрч даруй 2,449.6 сая ам.доллараар нэмэгдлээ. Монгол Улсын болон Засгийн газрын өрийн хэмжээ ийнхүү асар ихээр нэмэгдсэн нь валютын ханшид хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийсэн бол танилцуулна уу?

3. Төсвийн алдагдал 4 жил дараалан 2 их наяд төгрөгөөс давсан. Гэтэл шинээр өргөн мэдүүлсэн төсвийн тодотголд Нэгдсэн төсвийн тэнцлийг бас дахин 2 их наяд 771 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ. Төсвийн алдагдал бол өр юм. Ийнхүү Та бүхэн засаглаж байх хугацаанд нийтдээ 12 их наяд төгрөг давсан төсвийн алдагдал гаргасан байна. Түүхэн дээд амжилт тогтоож байгаа ийм хэмжээний архагшсан алдагдал бол зөвхөн дайны хөлд нэрвэгдсэн улс орнуудын төсөөт байдаг үзэгдэл юм. Ийм их алдагдал үндэсний мөнгөн тэмдэгтийн ам.доллартай харьцах ханшид хэрхэн нөлөөлж байгаа талаар тооцоо судалгаа хийсэн бол танилцуулна уу?

4. Эдийн засгийн хямрал нүүрэлсэн 2015 онд экспортод 4 тэрбум 669.3 сая ам.долларын бараа, түүхий эд гаргаж байсан бол 2019 онд 7 тэрбум 619.7 сая ам.долларт хүрч 3 тэрбум ам.доллар-аар өссөн байна. Ийнхүү эрдэс баялгийн бүтээгдэхүүний борлуулалтаас орж ирэх валют асар их хэмжээгээр нэмэгдэж байхад ам.долларын ханш ямар шалтгаанаар буурахгүй байгааг тайлбарлана уу? Монгол улс гадаад худалдаанаас орж ирэх валютаа хянаж чадаж байна уу?

5. Ханшийг тогтоох зорилгоор Монголбанкнаас хийсэн валютын интервенцийн дүнг 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд сар бүрээр тооцон гаргаж ирүүлнэ үү.

6. Монголбанкны цэвэршүүлсэн алтны мэдээг 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс өнөөдрийг хүртэлх хугацаанд сар бүрээр ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б. ПҮРЭВДОРЖ

2020000084